

Эрдэнэ Ресурс нь хайгуулын хөтөлбөрөөр шинэ Хар Морь талбайн эрдэсжилтийг 500 метрээр тэлж, үргэлжлүүлэн судлах хайгуулын хөтөлбөрийг эхлүүлээ

Хэвлэлийн мэдээ
Нова Скошиа муж, Халифакс хот
2021.01.27

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Хар Морь талбайд 2020 онд хийсэн хайгуулын өрөмдлөгийн эцсийн үр дүнгүүдийг танилцуулж, энэхүү шинэ талбайг үргэлжлүүлэн судлах хайгуулын хөтөлбөрийг эхлүүлснийг мэдээлэхэд таатай байна.

Онцлох мэдээлэл¹:

- 2020 оны 4-р улиралд хийгдсэн өрөмдлөгөөр Хар Морь талбайд алтны томоохон шинэ нээлтийг тодорхойлсон
 - Баян Хөндийгөөс хойд зүгт Алтан Сум талбайн хооронд зүүн хойд трендийн структурын дагуу, хойд өмнөд (N-S) тренд бүхий 4 км урт структур тодорхойлсон.
- Хар Морь дахь AAD-61 цооног нь алтны эрдэсжилт бүхий өргөн интервал огтолсон.
 - Цооногоос 10 метрийн гүнээс эхлэн 0.53 г/т алтны агуулга бүхий 130 метрийн интервал огтолсон нь цооногийн 14 метрээс 1.1 г/т алтны агуулга бүхий 26 метрийн интервал агуулж байна.
 - Энэхүү цооног нь өмнө танилцуулсан өндөр агуулга бүхий AAD-58, түүнээс хойд зүгт 500 метрт орших AAD-57 цооногуудаас хойд зүгт 700 метрт байрлалтай.
- Хар Морь талбайн Хойд Өмнөд (N-S) структурын дагуу 1.2 км-ийн трендэд томоохон алтны эрдэсжилт огтолсон, үүнд (өмнөд зүгээс хойд зүг рүү):
 - AAD-58 цооногийн 10 метрээс эхлэн 5.97 г/т алтны агуулга бүхий 45 метрийн интервал огтолсон нь 82.5 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал багтаасан 27.1 г/т алтны агуулга бүхий 8 метрийн интервал агуулж байна.
 - AAD-58 цооногоос хойд зүгт 180 метрт орших AAD-57 цооног нь 52 метрээс эхлэн 0.6 г/т алтны агуулга бүхий 16 метрийн интервал огтолсон нь 194 метрээс эхлэн 1.7 г/т алтны агуулга бүхий 30 метрийн интервал багтаасан 1.2 г/т алтны агуулга бүхий 48 метрийн интервал агуулж байна.
 - AAD-58 цооногоос хойд зүгт 500 метрт орших AAD-61 цооногт 10 метрээс эхлэн 0.53 г/т алтны агуулга бүхий 130 метрийн интервал огтолсон.
 - AAD-58 цооногоос хойд зүгт 1.2 км-т орших AAD-51 цооногт 138 метрээс эхлэн 5.6 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал, 222 метрээс эхлэн 0.9 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервалуудыг огтолсон.

¹ Хэвлэлийн мэдээнд тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропийг тодорхойлох боломжтой.

Тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: 2020 оны эцсийн үр дүнгүүдэд тулгуурлан Хар Морь талбайг Баян Хөндий ордын нээлтээс хойш Хөндий Алтны Дүүрэг дэх хамгийн чухал нээлт хэмээн тодорхойлж байна. Өрөмдлөгийн интервалууд, дөрвөн километр трендийн турш тодорхойлогдож буй геофизикийн болон геохимийн тэмдэглэл нь Хар Морь талбайн хэтийн төлөвийг баталгаажууллаа.”

“Энэхүү нээлтийн талаар нарийвчлан судлаж, хайгуулын цогц хөтөлбөрийг боловсруулахаар экспертүүдийн багтай хамтран ажиллахаар болоод байна. Бид 2021 оны 1-р улиралд хайгуулын хөтөлбөрүүдийг эрчимтэй хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд хөтөлбөр эцэслэгдмэгц дэлгэрэнгүй танилцуулна.”

Хар Морь (Dark Horse) нээлтийн тухай

(План зураг болон хөндлөн зүсэлтийн зурагтай хавсралтаас танилцана уу)

2020 оны 12 сард эцэслэсэн Хар Морь талбайн 2-р үе шатны өрөмдлөгийн хөтөлбөрөөр нэмэлт 3,085 метр, 14 цооног өрөмдсөн. 2020 онд Эрдэнэ Ресурс нь Хар Морь талбайд нийт 4,660 метр, 25 цооног (AAD-40-аас 64 хүртэл) өрөмдсөн. 2-р үе шатны өрөмдлөг нь тэлэлтийн бүсүүдийн тайлал бүхий томоохон структуртай холбоотой индикатор элементүүд (As, Mo, Sb)-ийн огтлол, бага соронзонгийн гажилт болон хөрсөн дэх алтны гажилттай холбоотой структуруудын огтлол бүхий 1-р үе шатны өрөмдлөгийн үр дүнд тулгуурласан.

Энэхүү шинэ нээлт нь Хар Морь талбайн хязгаарлагдмал судалгаа хийгдсэн хэсэгт оршиж байгаа бөгөөд 30.6 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал огтолсон AAD-48 цооноогоос ([2020 оны 10 сарын 26-ны хэвлэлийн мэдээтэй танилцана үү](#)) баруун зүгт 1 км-т байрлана. Энэхүү хэвлэлийн мэдээгээр мэдээлсэн AAD-61 цооног нь урьд нь танилцуулсан, хоорондоо 500 метр зайтай орших AAD-51 ба AAD-57 ([2021 оны 1 сарын 6-ны хэвлэлийн мэдээтэй танилцана үү](#)) цооногуудын дунд буюу AAD-57 цооноогоос өмнө зүгт 180 метрт оршиж байна.

AAD-61 цооногт 14 метрээс эхлэн 1.1 г/т алтны агуулга бүхий 26 метр багтаасан 0.53 г/т алтны агуулга бүхий 130 метрийн интервал огтолсон нь Хар Морь талбайн хамгийн зузаан алтны эрдэсжилт бүхий бүс юм. AAD-61 цооног дахь алтны эрдэсжилт нь 130 метрийн интервалын турш үргэлжилж буй бөгөөд цооногийн 126 метрт 3.5 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал огтолсон нь танилцуулсан хамгийн өндөр агуулга юм. Хар Морь талбайн Хойд Өмнөд структурын дагуу алтны эрдэсжилтийн үр дүнгүүдэд: AAD-51 цооногт хэд хэдэн алтны аномаль бүс илрүүлсэн бөгөөд үүнд 222 метрт 0.9 г/т алтны агуулга бүхий 10 метр интервал, 138 метрт 5.6 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал огтолсон. AAD-58 цооногт 10 метрээс эхлэн 5.97 г/т алтны агуулга бүхий 45 метрийн интервал огтолсон. AAD-57 цооногт 52 метрээс эхлэн 0.6 г/т алтны агуулга бүхий 16 метрийн интервал, 194 метрээс эхлэн 1.2 г/т алтны агуулга бүхий бүхий 48 метрийн интервал огтолсон. Дээрх дөрвөн цооногийн үр дүнгүүдийг Хүснэгт 1-т танилцуулав.

Хүснэгт 1 - Хар Морь Хойд-Өмнөд структурын дагуу хийсэн хайгуулын хөтөлбөрийн үр дүн (0.3 г/т алтны агуулгаас дээш агуулга бүхий интервалууд)

Цооног	(м) -ээс	(м) хүртэл	Интервал ⁽¹⁾	г/т Алт ⁽²⁾
AAD-51	138	141	3	5.61
Үүнд	140	141	1	16.22
Ба	222	232	10	0.92
AAD-57	52	68	16	0.58
Ба	160	180	20	0.45

Цооног	(м) -ээс	(м) хүртэл	Интервал ⁽¹⁾	г/т Алт ⁽²⁾
Ба	194	242	48	1.18
Үүнд	202	232	30	1.74
AAD-58	10	55	45	5.97
Үүнд	32	54	22	11.98
Үүнд	36	37	1	21.18
үүнд ⁽³⁾	41	49	8	27.07
үүнд	43	44	1	82.53
AAD-61 ⁽⁴⁾	10	140	130	0.53
Үүнд	14	40	26	1.06
Үүнд	92	96	4	1.25
үүнд	120	129	9	1.07

¹ Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Хар Морь талбайд эрдэсжсэн бүсийн чиглэлийг тодорхойлох хангалттай өрөмдлөг хийгдээгүй тул одоогоор бодит зузааныг тодорхойлох боломжгүй. Хайгуулын өрөмдлөгийн цооногууд нь (зөв өнцгөөр) 45-75 градусын уналтаар энгийнээс боломжит эрдэсжсэн талбайн трендийн дагуу өрөмдсөн

² Тайлагнасан интервалын агуулга нь дунджаар 1-2 метр интервалын дээжид тулгуурласан жигнэсэн дундаж агуулга болно. Дээд хязгаарлалт хийгээгүй боловч 10 г/т алтны агуулгаас өндөр агуулга бүхий интервалыг тодруулахаар тусад нь тайлагнадаг.

³ 1 метр интервал бүхий 8 дээжийн 7-д нь 10 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн ба 8 дахь дээжид 9.5 г/т алтны агуулга илэрсэн. Хамгийн өндөр агуулга бүхий интервал (43-44 метр) -ыг тусад нь тайлагнасан.

⁴ Шинээр мэдээлсэн үр дүнгүүд

Тэмдэглэл: AAD-60, AAD-62, AAD-63 ба AAD-64 цооногуудад аномаль алт ба/эсвэл индикатор элементүүд (As, Mo, Sb) огтолсон боловч 0.3 г/т алтны агуулгаас өндөр интервал огтлоогүй.

AAD-61 цооногийг хуурай саарь илэрсэн эпитеpmаль кварц штокверк брекч болон цагаан гялтгануурын бүстэй хамааралтай соронзон бага аномалийг судлахаар өрөмдсөн. AAD-61 цооног нь хүчтэй исэлдсэн, кварц-серицит-пирит (“QSP”)-ээр хувирсан дацит порфиороор зүсэгдсэн, ширхэгжсэн, нээлттэй кварц лимонитийн судал болон хүчтэй кварц штокверкийн бүстэй захлан оршиж байна. Цооногийн гүнрүү дунд зэргийн тархалттай пирит, пиритийн судланцарууд нэмэгдэж байна. 124 метрийн гүн хүртэл кварц-серицит-пирит (“QSP”) хувирлын хүч болон судлууд нь хувьсаж байгаа бөгөөд 141 метрийн гүн хүртэл кварц штокверкийн хүчтэй хувирсан судлыг агуулж буй бүсүүд нь хэд хэдэн үе шатаар өргөн сульфид эрдэсжсэн хар эпитеpmаль брекчийг агуулж, үүнийг дундаж хувирсан улаан дацит порфир бүхий бага зэргийн ширхэгжсэн саарал кварц ба кварц адулярын судлууд дагасан. Нам соронзон утгаар тодорхойлогдсон Хойд-Өмнөд (N-S) тренд структур нь 4 км-ийн турш үргэлжлэн, баруун зүг рүү Баян Хөндий ордтой холбогддог. Хойд-Өмнөд (N-S) эрдэсжсэн корридороос гадна AAD-61 цооногийн баруун болон өмнө бүсүүд нь 600м-ээс 400 метрийг хамран хэвтээ, хязгаарлагдмал илэрц бүхий хэд хэдэн хөрсний илэгдлийн цонхууд байгаа нь соронзон нам шинж чанар болон цагаан гялтгануурын хувиралтай төстэй байна.

Одоогоор хэтийн төлөв бүхий талбайд 6 цооног өрөмдсөн бөгөөд алтны эрдэсжилтийг шалгах судалгаа хязгаарлагдмал хийгдсэн. Хойд-Өмнөд нээлтийн бүсээс гадна Хар Морь талбай дахь геологийн шинж чанартай төстэй бусад судлагдаагүй талбайд хайгуулын судалгааг үргэлжлүүлэн хийнэ. Энэхүү судалгаа болон тайллыг боловсруулж байгаад:

- Компанийн хайгуулын баг хээрийн ажлуудыг үргэлжлүүлэн, нээлтийн цооногийн дээжүүдэд нарийвчилсан бүртгэл хийн, ирээдүйн хайгуулын хөтөлбөрт бэлдэх ажлуудыг гүйцэтгэж байна.
- Эпитеpmаль ба порфирын ордуудаар мэргэшсэн Др. Жеффри В.Хэдэнкист (Dr. Jeffrey W. Hedenquist) нь хайгуулын үр дүнгүүдэд шинжилгээ хийн, эрдэсжсэн системийн ойлголтыг сайжруулан, хөгжүүлэх болон ирээдүйн өрөмдлөгийн хөтөлбөрийг боловсруулахад зөвлөн ажиллана.

- Wave Geophysics-тэй энэхүү шинэ талбайн геофизикийн мэдээлэлд тайлал хийж, нарийвчлан судлахаар гэрээ хийсэн.
- Plus Minerals ХХК нь эрдэсжсэн системийн гүн болон шинж чанарын талаар ойлголт өгөх хэтийн төлөв бүхий талбайн гадаргын дээжлэлт ба цооногийн шаварлагийн эрдэсжилтийн (SWIR) судалгаа, тайллыг боловсруулна.
- Компанийн хайгуулын баг нь эрдэсжилтийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, өрөмдлөгийн бүсүүдийг тодорхойлох зорилгоор геологийн өгөгдөлд шинжилгээ хийх, үр дүнгүүд болон тайллуудыг гурван хэмжээст загварчлалд хөрвүүлнэ.

Дээрх ажлуудыг гүйцэтгэснээр өрөмдлөгийн хөтөлбөрийг боловсруулж, гүйцэтгэх нөхцөл бүрдэнэ.

Баян Хөндий 2020 оны 4-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөр

2020 оны 11-р сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий алтны ордын ойролцоо таван нэмэлт цооног өрөмдсөн. Нэг цооногийг Зүүн өмнөд Мидфийлд бүсийн эрдэсжилт тэлэх боломжийг тодорхойлохоор Мидфийлд бүсэд, нэг цооногийг ордын нөөцийн хязгаараас гадна эрдэсжилт үргэлжилж байгааг шалгахар өмнөд Страйкер бүсэд, гурван цооногийг уурхайн дэд бүтэц баригдахаар төлөвлөсөн бүс нь алтны эрдэсжилтгүйг батлахаар өрөмдсөн.

ВКD-346 гүехэн цооногийг Мидфийлдийн зүүн өмнөд бүсэд газрын дөт гүнд эрдэсжилт үргэлжилж буйг шалгахар өрөмдсөн. Энэхүү цооногт 27 метрээс (Юрийн галавын давхаргын гүн) цооногийн төгсгөл 62.1 метр хүртэл эрдэсжилт огтолсон бөгөөд 1.7 г/т алтны агуулга бүхий 35.1 метр интервал огтолсон. Үүнд 44 метрээс 62.1 метр хүртэл (цооногийн төгсгөл) 18.2 метрийн турш 2.86 г/т алтны агуулга бүхий өндөр агуулга бүхий бүс багтаж байна.

Нөөцийн хязгаараас гадна оршиг ВКD-268 цооногт 100 метр нягт үелэн хувирсан галт уулын туфыг огтолсон бөгөөд 100 метрийн гүнд алт агуулсан туф нь 2.45 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулж байсныг өмнөх хөтөлбөрөөр илрүүлсэн. Энэхүү ВКD-268 цооногийн эрдэсжилгийн үргэлжлэлийг шалгахар Өмнөд Страйкер бүсэд ВКD-349 цооногийг өрөмдсөн. ВКD-349 цооногт 75 метрийн гүнд, 140 метрийн зузаан үелэн хувирсан туфыг огтолсон ба 1 г/т алтны агуулга бүхий 3.3 метр зэрэг хэд хэдэн алтны эрдэсжсэн бүсүүдийг огтолсон.

Хүснэгт 2 – Баян Хөндий –Өрөмдлөгийн Үр дүнгүүдийн хураангуй

Цооног	(м) -ээс	(м) хүртэл	Интервал ⁽¹⁾	г/т Алт ⁽²⁾
ВКD-346	27	62.1 ⁽³⁾	35.1	1.70
Үүнд	44	62.1	18.1	2.86
Үүнд	57	59	2	8.77
ВКD-339	74.7	78	3.3	0.98
ба	118	122	4	0.49

¹ Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Өрөмдлөгийн цооногууд нь баруун өмнөд унал, баруун хойд баруун алтны судлыг хэвийн огтлоход чиглэсэн байсан тул мэдээлсэн зузаан нь бодит зузаантай дүйцэхүйц байна.

² Тайлагнасан интервалын агуулга нь дунджаар 1-2 метр интервалын дээжид тулгуурласан жигнэсэн дундаж агуулга болно. Дээд хязгаарлалт хийгээгүй боловч 10 г/т алтны агуулгаас өндөр агуулга бүхий интервалыг тодруулахаар тусад нь тайлагнадаг.

³ Цооногийн төгсгөл

Одоогоор Баян Хөндий алтны ордын ойролцоо өрөмдлөг хийхээр төлөвлөөгүй бөгөөд өнөөг хүртэл хийгдсэн хайгуулын үр дүнгүүдэд тулгуурлан 2021 оны 1-р улиралд ашигт малтмалын нөөцийг шинэчлэн тооцоолохоор төлөвлөж байна.

COVID-19 цар тахлын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ:

2020 оны 11 сард Covid-19 вирусний халдвар голомтлон тархсанаас үүдэн Монгол Улсын Засгийн газар дотоодын хөл хөдөлгөөн, бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний салбарт хязгаарлалт хийгдсэн. Хэдийгээр аймгуудад хөл хориог сулруулж байгаа боловч Улаанбаатар хотод бизнесийн болон олон нийтийн үйл ажиллагаа хэвийн явуулахад хязгаарлалттай хэвээр байна. 2020 оны 12-р сард хээрийн ажлуудыг зогсоогоод байсан бөгөөд 2021 оны 1-р сард Засгийн газрын уул уурхай, ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагааны удирдамжийн дагуу хайгуулын хөтөлбөрийг эхлүүлсэн. Компанийн Монгол Улс дахь ажилтнууд компанийн болон засаг захиргааны байгууллагуудын заавар, зөвлөмжийн дагуу аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

COVID-19 вирусний тархалтаас урьдчилан сэргийлэхэд бие сэтгэлээ зориулж буй эрүүл мэндийн ажилтан албан хаагчид, цагдаа, тусгай үүргийн албан хаагч нарт компанийн зүгээс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хөндий Алтны Дүүргийн Тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц² (“Measured and Indicated Resources”)³, 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (“Inferred Resources”) тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтдаг. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7-р сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Нарийвчилсан ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор боловсруулахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2022 онд эхлүүлнэ.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь

² Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2019 оны 12 сарын 4-нд SEDAR-т байршуулсан Тетра Текийн боловсруулсан NI 43-101 техникийн тайлангаас танилцана уу.

³ Баттай ба бодит геологийн нөөц: 3.77 г/т алтны агуулга бүхий 171,000 унц баттай нөөц, 2.93 г/т алтны агуулга бүхий 349,700 унц бодит нөөц

Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологч) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)–ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмет спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 гр дээжний 75 микроноос бага байх 30 гр бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцганд үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнэ Ресурсийн ложистикийн гэрээт Монруд ХХК гүйцэтгэдэг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>

KHUNDII GOLD DISTRICT

Three deposits, multiple greenfield discoveries, limited exploration

Altan Nar Deposit (Au, Ag, Zn, Pb)

Nomin Tal

Road to Shinejinst

Oyut Khundii

Proposed Haulroad

Altan Arrow

Khuvyn Khar

Dark Horse Gold Prospect

Zuun Mod Deposit (Cu, Mo)

Ulaan

Khundii North

Bayan Khundii Deposit (Au)

□ Exploration licenses

■ Mining licenses

● Au

● Cu

● Ag

● Mo

● Pb

● Zn



KHUNDII GOLD PROSPECT MAP



**Ulaan Prospect
Pervasive and Intense
QSP Alteration Zone**

AAD-61



AAD-57



AAD-58



Dark Horse Gold Discovery

**Bayan Khundii
Low Sulphidation
Epithermal Gold Deposit**

Resources

521 Koz M&I @ 3.16 g/t Gold

103 Koz Inf. @ 3.68 g/t Gold

2km



ANOMALOUS GOLD + ARSENIC SOIL SIGNATURE MAP

Gold + Arsenic
in Soil
≥ 75th
Percentile

AAD-51
3m of 5.6 g/t &
5m of 1.4 g/t Au

AAD-61
130m of 0.53 g/t Au
Incl. 26m of 1 g/t Au

AAD-57
82m of 0.8 g/t Au incl.
30m of 1.7 g/t Au

AAD-58
45m of 6.0 g/t Au
Incl. 8m of 27 g/t Au

300m

HYDROTHERMAL ALTERATION MAP

Quartz-Sericite-
Sulphide Alteration
Advanced Argillic
Alteration
Residual (Vuggy)
Silica Bodies

300m

MAGNETITE DESTRUCTIVE CORRIDOR

AAD-61 Section

AAD-57 Section

AAD-58 Section

300m

AAD-61 SECTION

Projected Hydrothermal Alteration Concept and Downhole Gold

White Mica Alteration Surface Exposure

Au + As Soil Anomaly

AAD-61

26m of 1.1 g/t Gold

4m of 1.3 g/t Gold

130m of 0.53 g/t Gold

9m of 1.1 g/t Gold

Interpolated QSP Alteration



100m

AAD-61: 125-129: 4m @ 1.5 g/t Gold; intensely QSP altered volcanic, cut by multi-stage black epithermal quartz breccia and stockwork



AAD-57 SECTION


Projected Hydrothermal Alteration Concept and Downhole Gold

White Mica Alteration Surface Exposure

Au + As in Soil Anomaly

AAD-57

AAD-34



16m of 0.58 g/t Gold

82m of 0.81 g/t Gold

30m of 1.7 g/t Gold

Interpolated QSP Alteration

100m

AAD-57: 202-206 metres: 4m @ 4.6 g/t Gold; intensely QSP altered volcanic, breccia, sugary quartz carbonate sulfide veins



White Mica Alteration Zone and Residual Silica Body

Au + As in Soil Anomaly

AAAD-58

Interpolated QSP Alteration

45m of 6 g/t Gold Incl. 8m of 27 g/t Gold

Anomalous copper (>300 ppm) over final 20m in intense stockwork pyrite veinlets to massive pyrite veins in QSP altered volcanic

100m

AAAD-58: 36-50 metres; 14m @ 18.2 g/t Gold; strongly QSP altered volcanic, cut by sugary crustiform qtz-lim-pyrite veins and intense iron oxide weathering along fault

	21.2
	1.22
	3.8
	7.4
	0.8
	36.2
	31.3
	82.5
	15.0
	12.7
	16.7
	9.5
	12.5
	4.5

Au 1m g/t

Gold g/t

